



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2010 оны 12 сарын 09 өдөр

Улаанбаатар хот

Төрийн ордон,

БАЙГАЛИЙН УРГАМАЛ АШИГЛАСНЫ

ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД

ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйл:

“5 дугаар зүйл. Төлбөр тооцох үзүүлэлт

Ургамал ашигласны төлбөр тооцох үзүүлэлтийг ургамлын тухайн үеийн жинг килограммаар илэрхийлсэн нэгж дэх тухайн зүйл ургамлын тоо, хэмжээг тооцоолсон экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар тооцно.”

2/6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1.Ургамал ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний дор дурдсан хувиар тооцон төгрөгөөр тогтооно:

Төлбөр ногдох байгалийн ургамал	Төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний хувь	
	доод	дээд
	1.Нэн ховор	25
2.Ховор	15	20
3.Элбэг	5	10

”

3/11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

“1/төлбөрийн данс, баримтыг будлиантуулсан, ургамал ашигласны төлбөрийг төсвийн орлогод тогтоосон журмын дагуу тушаагаагүй бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.”

2 дугаар зүйл.Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “бэлнээр сум, дүүргийн Засаг даргын томилсон албан тушаалтанд, эсхүл бэлэн бусаар сум, дүүргийн төсөвт тус тус” гэснийг “сум, дүүргийн төсөвт” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бэлнээр хураасан төлбөрийг тухай бүр сум, дүүргийн төсөвт оруулна” гэснийг “төлбөрийг бэлнээр хураан авахыг хориглоно” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн 1 дэх заалтын “бэлэн болон бэлэн бусаар төсөвт оруулсан” гэснийг “ургамал ашигласны” гэж, мөн хэсгийн 3 дахь заалтын “Улсын татварын ерөнхий газарт” гэснийг “татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад” гэж, мөн хэсгийн 4 дэх заалт, 5 дахь хэсгийн “Улсын татварын ерөнхий газар” гэснийг “татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2010 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталсан Байгалын

ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Н.ЭНХБОЛД